



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн “Амгалан Итгэлэхүй” ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн хураангуй аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/173/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр  
Утас: 11315558 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)  
Аудитын менежер: Я.Алтанцэцэг  
Утас: 11315558 Цахим хаяг: [altantsetsegya@audit.gov.mn](mailto:altantsetsegya@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: СМД аудит ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал: Д.Гэндэнпэлжээ  
Утас: 99110699 Цахим хаяг: [munkhtsatsral@cmdaudit.mn](mailto:munkhtsatsral@cmdaudit.mn)  
Аудитор: А.Цээням  
Утас: 99442140 Цахим хаяг: [tseenyam1202@gmail.com](mailto:tseenyam1202@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	1
НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	6
3.1 Төлбөрийн акт .....	6
3.2 Албан шаардлага .....	6
3.3 Зөвлөмж.....	7
ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	8
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл .....	8
4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	8
Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл .....	8

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МӨАУМХ	Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТББ	Төрийн бус байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМС	Эрүүл мэндийн сайд

## НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.15 № 584  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ  
ДҮҮРГИЙН АМГАЛАН ИТГЭЛЭХҮЙ  
ӨЭМТ-ИЙН ДАРГА С.БАЯРМАА  
ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Амгалан Итгэлэхүй ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Амгалан Итгэлэхүй ӨЭМТ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 358.4 сая төгрөгийн, 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтээр 107.5 сая төгрөгийн, нийт 465.9 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, эрүүл мэндийн ерөнхий газрын санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 73 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 95.8 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж,

C:\Users\narangua\Desktop\Бичиг хураангуй\2026\20260315\1426050489

1426050489

үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 98.1 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. ХӨРӨНГӨ	-	-
1.1 Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	20,055.85	1,159,293.08
1.1.2 Дансны авлага	41,265,602.57	-
1.1.4 Бусад авлага	-	8,000,581.29
1.1.6 Бараа материал	43,979,435.81	40,178,483.19
1.1.11 Эргэлтийн хөрөнгийн дүн	85,265,094.23	49,338,357.56
1.2 Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1 Үндсэн хөрөнгө	161,480,581.72	109,854,459.75
1.2.2 Биет бус хөрөнгө	2,144,999.95	1,572,999.91
1.2.10 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	163,625,581.67	111,427,459.66
<b>1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>248,890,675.90</b>	<b>160,765,817.22</b>
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1 Өр төлбөр	-	-
2.1.1.4 НДШ - ийн өглөг	2,700,000.00	5,000,000.00
2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр	469,000.00	110,000.00
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,169,000.00	5,110,000.00
2.2 Өр төлбөрийн нийт дүн	3,169,000.00	5,110,000.00
2.3 Эздийн өмч	-	-
2.3.1 Өмч:	54,052,563.70	54,052,563.70
2.3.1.1 - төрийн	53,552,563.70	53,552,563.70
2.3.1.2 - хувийн	500,000.00	500,000.00
2.3.4 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,017,000.00	4,017,000.00
2.3.7 Хуримтлагдсан ашиг	187,652,112.20	97,586,253.52
2.3.9 Эздийн өмчийн дүн	245,721,675.90	155,655,817.22
<b>2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>248,890,675.90</b>	<b>160,765,817.22</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3. Нийт ашиг ( алдагдал)	-	-
4. Санхүүжилтийн орлого	503,574,486.24	465,927,930.60
5. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	61,406,775.14	4,963,653.15
8. Бусад орлого	-	6,656,410.51
10. Ерөнхий ба удирдлагын зардал	622,081,716.08	569,715,239.03
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(57,100,454.70)	(92,167,244.77)
19. Орлогын татварын зардал	-	-
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(57,100,454.70)	(92,167,244.77)

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
2. Залруулсан үлдэгдэл	54,052,563.70	4,017,000.00	244,752,566.90	302,822,130.60
3. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(57,100,454.70)	(57,100,454.70)
8. Эхний үлдэгдэл /төгрөгөөр/	54,052,563.70	4,017,000.00	187,652,112.20	245,721,675.90
9. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	2,101,386.09	2,101,386.09
10. Залруулсан үлдэгдэл	54,052,563.70	4,017,000.00	189,753,498.29	247,823,061.99
11. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(92,167,244.77)	(92,167,244.77)
16. Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/	54,052,563.70	4,017,000.00	97,586,253.52	155,655,817.22

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>1.1 Мөнгөн орлогын дүн</b>	<b>485,486,289.80</b>	<b>507,903,248.35</b>
1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	485,486,289.80	501,246,837.84
1.1.2 Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3 Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4 Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5 Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6 Бусад мөнгөн орлого	-	6,656,410.51
<b>1.2 Мөнгөн зарлагын дүн</b>	<b>524,379,686.10</b>	<b>506,764,011.12</b>
1.2.1 Ажиллагчдад төлсөн	423,785,530.01	381,615,022.20
1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	33,408,506.10	40,348,892.42
1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	67,185,649.99	84,800,096.50
1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн	-	-
1.2.7 Татварын байгууллагад төлсөн	-	-
<b>1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(38,893,396.30)</b>	<b>1,139,237.23</b>
<b>3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
3.1 Мөнгөн орлогын дүн	-	-
3.2 Мөнгөн зарлагын дүн	-	-
3.3 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
<b>4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(38,893,396.30)</b>	<b>1,139,237.23</b>
<b>5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>38,913,452.15</b>	<b>20,055.85</b>
<b>6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>20,055.85</b>	<b>1,159,293.08</b>

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийцлийн аудиттай холбоотой 36,277.4 мянган төгрөгийн 1 зөрчил илэрч албан шаардлага хүргүүлэн, санхүүгийн тайлагналтай холбоотой 3,037.5 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрснээс 506.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2,530.8 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 3,037 мянган төгрөгийн санхүүгийн тайлагналтай холбоотой зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

- Ажилтнуудад 506.7 мянган төгрөгийн үндсэн цалинг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Илүү олгосон цалингийн 506.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 3.2 Албан шаардлага

- Тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийн 36,277.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал:

Бараа материалын худалдан авалтын анхан шатны баримт болох цахим төлбөрийн и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаар шивүүлээгүй 2,530.8 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж нь: Бэлтгэн нийлүүлэгчдээр цахим төлбөрийн и-баримтыг бүрэн шивүүлж гүйлгээг хийж хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг НТАГ-т 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодогч ажилтнуудад 506.7 мянган төгрөгийн үндсэн цалинг илүү тооцож олгосон байна.	1	506.7	1	506.7				
Бараа материалын худалдан авалтын анхан шатны баримт болох цахим төлбөрийн и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаар шивүүлээгүй 2,530.8 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна.	1	2,530.8					1	2,530.8
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>3,037.5</b>	<b>1</b>	<b>506.7</b>			<b>-</b>	<b>1</b>
								<b>2,530.8</b>

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийн 36,277.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.	1	36,277.4	1	36,277.4		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>36,277.4</b>	<b>1</b>	<b>36,277.4</b>		<b>-</b>

### Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөөс татгалзсан	
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийээгүй					
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ОНӨҮГ		1			1			
	<b>НИЙТ</b>		<b>1</b>			<b>1</b>			



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 05 дугаар сарын 13

№ 181/181990255

Улаанбаатар хот

11111-2026/193/111-СТА-01041

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Амгалан Итгэлэхүй Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилтнуудад 506,727.0 (таван зуун зургаан мянга долоон зуун хорин долоо) төгрөгийн үндсэн цалинг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Ажиллагсдад илүү олгосон 506,727.0 (таван зуун зургаан мянга долоон зуун хорин долоо) төгрөгийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Амгалан Итгэлэхүй Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга (С.Баярмаа), нягтлан бодогч (С.Хажидмаа) нараар төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү торгуулийн орлогын МН440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Амгалан Итгэлэхүй ӨЭМТ-ийн дарга (С.Баярмаа), нягтлан бодогч (С.Хажидмаа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
"СМД АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
Я.АЛТАНЦЭЦЭГ  
А.ЦЭЭНЯМ

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110172



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 231/Б1970205

Улаанбаатар хот

НТАГ - 2026/173/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Амгалан Итгэлэхүй Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 36,277,430.0 (гучин зургаан сая хоёр зуун далан долоон мянга дөрвөн зуун гучин) төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Амгалан Итгэлэхүй Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга С.Баярмаа, нягтлан бодогч С.Хажидмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
“СМД АУДИТ” ХХК-ИЙН АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
Я.АЛТАНЦЭЦЭГ  
А.ЦЭЭНЯМ



Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426090440